

САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЭЧЛЭЛ, ХУУЛИЙН ХЭЛТСИЙН
САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ
БАТМӨНХИЙН СОЛОНГЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах арга хэмжээний зохион байгуулалтыг хариуцна.							
1.	Арга хэмжээ 1.1. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын баталсан хүчин төгөлдөр үйлчилж байгаа захиргааны хэм хэмжээний актад хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.	Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь	0%	50%		01-06	40%
1.1.	Дэд арга хэмжээ 1.1.1. Захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтын судалгаа хийнэ.	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0	30%	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар 17 хуульд захиргааны хэм хэмжээний акт батлах 49 эрх олгосон заалт туссанаас 35 заалтын хүрээнд захиргааны хэм хэмжээний актыг баталсан байна.	01-02	30%
1.2.	Дэд арга хэмжээ 1.1.2. Хүчин төгөлдөр мөрдөж байгаа захиргааны хэм хэмжээний актад хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0	20%	Дээрх 35 акт тус бүрд хяналт шинжилгээ, үнэлгээг дараах 5 асуудлын хүрээнд хийж байна: 1. тэмдэглэх хэсэгт үндэслэл болгосон хуулиар тусгайлан эрх олгосон хуулийн заалтад өөрчлөлт орсон эсэх; 2. хавсралтаар баталсан журмын дотор үндэслэл болгож эшлэл хийсэн заалтууд	03-05	10%

					болон бусад зохицуулалтууд нь шинээр батлагдсан хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх; 3.бүртгэлтэй шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулсан болон хүчингүй болгосон шийдвэрээ тухай бүрд нь ирүүлж сан холбогдох хөдөлгөөн хийсэн эсэх; 4.ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөхгүй болсон шийдвэрийг сангаас хасуулах арга хэмжээ авсан эсэх; 5.улсын нэгдсэн санд бүртгүүлээгүй шийдвэр байгаа эсэх, хуульд нийцүүлэн бүртгүүлэх арга хэмжээг авсан эсэх.		
1.3	<i>Дэд арга хэмжээ 1.1.3.Хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, зөвлөмжийн дагуу холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлнэ.</i>	<i>Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь</i>	0	-	Дүгнэлт, зөвлөмж гараагүй байгаа болно.	07-09	-
2.	Арга хэмжээ 1.2.Захиргааны хэм хэмжээний актын тоог цөөрүүлэх, журмаар зохицуулах харилцааг холбогдох хуульд тусгах асуудлаар салбарт хамаарах Засгийн газрын тогтоолоор баталсан хэм хэмжээний актад хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.	Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь	0%	50%		01-06	40%
2.1.	<i>Дэд арга хэмжээ 1.2.1.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудалд хамаарах хуулиар Засгийн газарт захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтын судалгаа хийнэ.</i>	<i>Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь</i>	0%	30%	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар 17 хуульд захиргааны хэм хэмжээний акт батлах 35 эрх олгосон заалт туссанаас 26 заалтын хүрээнд захиргааны хэм хэмжээний актыг баталсан байна.	02-04	30%
2.2.	<i>Дэд арга хэмжээ 1.2.2.Хүчин төгөлдөр мөрдөж байгаа захиргааны хэм хэмжээний актад хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.</i>	<i>Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь</i>	0%	20%	Дээрх 35 акт тус бүрд хяналт шинжилгээ, үнэлгээг дараах 5 асуудлын хүрээнд хийж байна: 1.тэмдэглэх хэсэгт үндэслэл болгосон хуулиар тусгайлан эрх олгосон хуулийн заалтад өөрчлөлт орсон эсэх; 2.хавсралтаар баталсан журмын дотор үндэслэл болгож эшлэл хийсэн заалтууд	05-07	10%

					болон бусад зохицуулалтууд нь шинээр батлагдсан хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх; 3.бүртгэлтэй шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулсан болон хүчингүй болгосон шийдвэрээ тухай бүрд нь ирүүлж сан холбогдох хөдөлгөөн хийсэн эсэх; 4.ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөхгүй болсон шийдвэрийг сангаас хасуулах арга хэмжээ авсан эсэх; 5.улсын нэгдсэн санд бүртгүүлээгүй шийдвэр байгаа эсэх, хуульд нийцүүлэн бүртгүүлэх арга хэмжээг авсан эсэх.		
2.3.	<i>Дэд арга хэмжээ 1.2.3.Хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, зөвлөмжийн дагуу холбогдох саналыг боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлнэ.</i>	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	-	Дүгнэлт, зөвлөмж гараагүй байгаа болно.	07-09	-
3.	Арга хэмжээ 1.3.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохтой холбоотой эрх зүйн орчны судалгаа хийж, холбогдох хууль, захиргааны хэм хэмжээний актад өөрчлөлт оруулах санал боловсруулах, саналыг олон нийтээр хэлэлцүүлнэ.	Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь	0%	100%		02-06	100%
3.1.	<i>Дэд арга хэмжээ 1.3.1.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдаас баталсан тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой захиргааны хэм хэмжээний актын судалгаа хийнэ.</i>	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	30%	Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийн дагуу салбарт мөрдөж байгаа зөвшөөрөлтэй холбоотой харилцааг зохицуулж байгаа салбарын сайдаас баталсан 2, Харилцаа холбооны Зохицуулах хорооноос баталсан 44 актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж салбарын сайдаас баталсан 1 актыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/35 дугаар тушаалаар хүчингүй болгож, Цахим гарын үсгийн тухай хууль, Кибер аюулгүй	02-03	30%

					<p>байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг тус тус боловсруулаад байна.</p> <p>Харилцаа холбооны Зохицуулах хорооноос баталсан 27 актыг хуулиар захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгогдоогүй, хуулиар олгосон эрхийг хэтрүүлсэн, Зөвшөөрлийн тухай хуулийг зөрчсөн, бизнес эрхлэгчдэд дарамт, тээг болсон шат дамжлага үүсгэсэн шинжтэй гэж үзэж зөрчилтэй актуудыг хуульд нийцүүлж, хүчингүй болгох арга хэмжээ авах талаар чиглэл хүргүүлсэн.</p> <p>Тус хорооноос 6 актыг бүхэлд нь, 8 актын 82 заалтыг тус тус хүчингүй болгосон талаар 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/289 дугаартай албан бичгээр мэдэгдээд байна.</p>		
3.2.	<p>Дэд арга хэмжээ 1.3.2.Салбарын тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой Харилцаа холбооны зохицуулах хорооноос боловсруулсан хуулийн төслийн саналд салбарын байгууллагуудаас санал авна.</p>	<p>Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь</p>	0%	10%	<p>Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагаж боловсруулсан тус салбарын 5 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Мэдээлэл холбооны операторуудын ассоциаци болон үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид, харьяа байгууллагуудын хуульч нар, яамны албан хаагчдаас санал авах /албаны цахим шуудангийн хэмжээнээс хэтэрсэн тул/-аар 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр хүргүүлсэн.</p> <p>Харилцаа холбооны зохицуулах хороо, Мобиком корпораци ХХК, Юнител ХХК, Скайтел ХХК, Ондо ХХК нараас санал ирүүлснийг нэгтгэн санал дээр яамны болон Зохицуулах хорооны албан хаагчидтай хамтран ажилласан.</p>	05	10%
3.3.	<p>Дэд арга хэмжээ 1.3.3.Салбарын байгууллагуудаас ирүүлсэн саналыг нэгтгэн удирдлагуудаас санал авч, холбогдох байгууллагад хүргүүлнэ.</p>	<p>Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь</p>	0%	60%	<p>Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаас гарсан дүгнэлтийн дагуу зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон болон зөвшөөрөл олгоход ач холбогдолгүй цаг хугацаа шаардсан, шат</p>	05-06	60%

					дамжлага үүсгэсэн баримт бичгийг хүчингүй болгох хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас боловсруулсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийг дагаж боловсруулсан салбарт хамаарах хуулийн төслүүдэд Харилцаа холбооны Зохицуулах хороо болон салбарын үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн саналыг нэгтгэн цахимаар 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр боловсруулсан нь сайдаас зөвшөөрөл олгож байгаа төлөвтэй байна.		
Зорилт 2. Хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах талаар зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ.							
4.	Арга хэмжээ 2.1. Салбарын бодлогын болон бусад баримт бичгийг холбогдох албан хаагчидтай хамтран шинэчлэн боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулахад арга зүйн зөвлөгөө өгнө.	Арга зүйн зөвлөгөө үзүүлж хамтран ажилласан журмын тоо	51	12	1. "Хөдөлмөрийн дотоод журам", "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр", "Ахмадын санг ажиллуулах журам", "Албан томилолтын журам", "Салбарын шагнал олгоход мөрдөх журам"-ын төслийг хэлтсийн албан хаагчдын хамт боловсруулан батлуулсан. 2. Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан "Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журам", "Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам", Мэдээллийн технологийн "Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд заасан "виртуал бүсийн ажиллах журам", "Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам", Инновацийн тухай хуульд заасан "Инновацын төслийг улсын төсвөөс	01-06	100%

					<p>санхүүжүүлэх журам”, “Инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам”, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан “Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам”, Дэлхийн радио холбооны WRC23 хурлын шийдвэрийн дагуу Дэлхийн Радио холбооны дүрэм 2024 (ITU RR 2024)-ын нэмэлт, өөрчлөлтийг Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтийг шинэчлэн батлуулах ажилд холбогдох газар, хэлтсийн албан хаагчидтай хамтран ажилласан.</p> <p>3.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2, 22.9.10, 22.9.11-т заасан харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжих зорилгоор элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдээс олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг гаргасан ахуйн нэгж, байгууллагад хуульд заасан татварын хөнгөлөлт олгоход тавигдах шаардлагын төслийг боловсруулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/79 дүгээр тушаалаар батлуулсныг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 7258 дугаарт бүртгэсэн.</p>		
5.	<p>Арга хэмжээ 2.2. Сайд, Төрийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээнд гаргасан шийдвэртэй холбогдох эрх зүйн маргааныг хууль, шүүхийн байгууллагаар хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагын эрх ашгийг хамгаална.</p>	Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон хэргийн тоо	3	2	<p>1.Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/37 дугаар тушаалаар батлагдсан “Радио долгионы ашиглалт үйлчилгээний төлбөр тогтоох журам”-ын 2.2.8 дахь заалтыг хүчингүй болгуулах тухай Ондо ХХК-ын нэхэмжлэлтэй захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд</p>	01-06	100%

					<p>шинжээч С.Онончимэгийн хамт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажилласан бөгөөд тус компани гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсаныг шүүх баталгаажуулж, хэргийг хэрэгсэхгүй болгох захирамж гаргасан.</p> <p>2.Тус яаманд холбогдуулан Дүйнхэр тэргүүн ХХК-ийн нэхэмжлэлтэй Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн "Мэдэгдэл хүргүүлэх тухай" 03/1063 дугаартай албан бичгийг хүчингүй болгуулах", шалгарсан багцад гэрээ байгуулахыг даалгах талаарх захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд мэргэжилтэн Г.Болорчимэгийн хамт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажилласан. Шүүхээс 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн шийдвэрээр нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь ханган шийдвэрлэсэн бөгөөд давж заалдах гомдол гаргахаар ажиллаж байна.</p>		
6.	Арга хэмжээ 2.3.Хуулийн төсөл, Улсын Их хурлын тогтоолын төсөл, Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх	Санал өгсөн хууль, зарлиг, журам, тогтоолын төслийн тоо	31	-	Тайлант хугацаанд 51 албан бичиг удирдлагаас цохолттой ирснээс шийдвэрлэсэн 45, судлагдаж байгаа 6 албан бичиг байна. Үүнээс 18 албан бичгийн дагуу ирүүлсэн хууль, журмын төсөлд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын саналыг хүргүүлсэн.	01-06	100%
7.	Арга хэмжээ 2.4. Албан хаагчдад шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар мэдээллийг тухай бүрд өгөх, шаардлагатай сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.	Зохион байгуулсан танхимын сургалтын тоо	3	2	Худалдан авах ажиллагааны хүрээнд гарч байгаа асуудлууд болон албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар 2 удаа дотоод сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн.	07-12	-
<p align="center">Зорилт 3. Сайд, Төрийн нарийн бичгийн даргын шийдвэрийн эрхзүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл дэмжлэгээр хангана.</p>							

8.	Арга хэмжээ 3.1. Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын эрх зүйн үндэслэлийг хангуулна.	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	-	100%		01-06	100%
8.1.	Арга хэмжээ 3.1.1.Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төслийн эрх зүйн үндэслэлийг хянаж, хууль тогтоомжид нийцүүлэх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	70%	Үйл ажиллагаатай холбоотой сайдын 84, Төрийн нарийн бичгийн даргын 190, хүний нөөцтэй холбоотой сайдын 18, Төрийн нарийн бичгийн даргын 77 тушаалын эрх зүйн үндэслэл, найруулгыг хянаж засвар оруулсан. Үүнээс 25 тушаалын төслийг хариуцсан албан хаагчид боловсруулж өгсөн.	01-06	70%
8.2.	Арга хэмжээ 3.1.2.Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын бүртгэл хөтлөх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	5%	Сайдын болон Төрийн нарийн бичгийн даргын 369 тушаалд дугаар олгож, боловсруулсан албан хаагчид хувийг хүргүүлсэн.		5%
8.3.	Арга хэмжээ 3.1.3.Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын цахим хувийг үүсгэх, байгууллагын дотоод сүлжээнд байрлуулах	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	10%	Сайд, Төрийн нарийн бичгийн даргын үйл ажиллагаатай холбоотой гарсан А тушаалыг баталгаажсанаас хойш 7 хоногийн дотор сканердаж цахим хувийг байгууллагын дотоод удирдлагын системийн Файлын санд албан хаагч танилцах боломжоор хангаж байрлуулж байна.		10%
8.4.	Арга хэмжээ 3.1.4.Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалыг архивт шилжүүлэх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	15%	Бүтцийн өөрчлөлт орохоос өмнө болон хойно гарсан нийт 770 тушаалыг архивын нэгж болгон хадгалахаар бэлтгэсэн ба хавтаслаж үдэх ажил дутуу байна.	03	10%
Зорилт 4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулна.							
9.	Арга хэмжээ 4.1. Нийтийн албан тушаалтны 2024 оны хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийн тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ.	Тайлангийн гүйцэтгэлийн хувь	-	100%		01-02	100%
9.1.	Арга хэмжээ 4.1.1.Тус яамны болон харьяа байгууллагын нийтийн албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчдын жагсаалтыг нэгтгэж Авлигатай тэмцэх газрын хариуцсан ЭБАТ-д хүргүүлэх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	15%	Тус яамны болон харьяа байгууллагын 2024 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах 118 албан тушаалтны нэрсийн жагсаалтыг маягтын дагуу нэгтгэн 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 03/45 дугаартай албан бичгээр	01	15%

					Авлигатай тэмцэх газарт, 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр хариуцсан ажилтан Энхжингийн enkhjin@iaac.mn албаны цахим шуудангаар тус тус хүргүүлсэн.		
9.2.	Арга хэмжээ 4.1.2. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн системд мэдүүлэг гаргавал зохих албан хаагчийн эрхийг үүссэн эсэхийг шалгах, давхар үүссэн эрхийг устгах	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	5%	Тухайн жилд нэгж хооронд шилжин томилогдсон, хүүхэд асрах чөлөө авсан, ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчийн бүртгэл мэдүүлгийн бүрдүүлэлтийн системд шинэчилсэн мэдүүлэг гаргах эрх үүсгэхэд давхардаж үүсдэг бөгөөд нэрийн жагсаалтад орсон албан хаагч бүрээр тулгаж давхардсан бүртгэлийг устгасан болно.	01	5%
9.3.	Арга хэмжээ 4.1.3. Албан хаагчид болон салбар ЭБАТ-д мэдүүлэг гаргах талаарх арга зүйн заавар, зөвлөгөөг өгөх, сургалт зохион байгуулах	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	20%	Шинэчилсэн мэдүүлэг гаргахтай холбогдуулан яамны албан хаагчид болон харьяа ЭБАТ-уудыг тогтмол мэдээллээр хангаж ажилласан ба "ЦХИХХЯ-ны Салбар ЭБАТ-ууд" групп чатыг нээж ЭБАТ-уудад тухай бүрд заавар, зөвлөгөө өгч ажилласан.	01	20%
9.4.	Арга хэмжээ 4.1.4. Хуулийн хугацаанд гаргасан мэдүүлгийг шалган баталгаажуулах, ЭБАТ-ын бүртгэл хөтлөх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	40%	Мэдүүлэг гаргавал зохих 121 албан хаагчийн гаргасан мэдүүлгийг тухай бүрд шалган, холбогдох заавар зөвлөмжөөр хангаж, мэдүүлгийн бүрдүүлэлтийн системд баталгаажуулсан.	01	40%
9.5.	Арга хэмжээ 4.1.5. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн системээс татсан тайланг хянан холбогдох засварыг оруулах, удирдлагаар баталгаажуулж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	20%	Тус яамны болон харьяа байгууллагын албан хаагчдын "Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн 2024 оны тайлан"-г баталгаажуулан хүргүүлж байна. Мөн мэдүүлгийн бүрдүүлэлтийн системээс "Мэдүүлэг гаргагчийн 2024 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуй мэдээ", "2024 оны мэдүүлэг гаргагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн хураангуй мэдээ", "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаж өгөөгүй, гаргахаас татгалзсан, хугацаа хожимдуулсан албан тушаалтны бүртгэл", "Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн	02	20%

					хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн бүртгэл”, “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг мэдүүлсэн тухай бүртгэл”-ийг татан баталгаажуулсныг 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 03/537 дугаартай албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.		
10.	Арга хэмжээ 4.2. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулна.	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	100%		01-06	80%
10.1.	Арга хэмжээ 4.2.1.Авлигын эсрэг сүлжээнд байгууллагын 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг баталгаажуулах	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	0%	100%	Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар Цэнд-Аюуш, мөн хэлтсийн ажилтан, комиссар Бямбадорж нартай хамтран төрийн байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх авлигын эсрэг төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнахтай холбоотой асуудлаар тус яамны харьяа байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудыг хамруулсан аргазүйн зөвлөгөө өгөх уулзалтыг 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Тус яамнаас 2025 онд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4 зорилтын хүрээнд 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Төлөвлөгөөг http://khutulbur.iaac.mn/iaac/plan/ цахим системд бүртгэх эрхийг Авлигатай тэмцэх газраас нээж өгөөгүй цахим системд бүртгээгүй болно. Мөн харьяа 4 үйлдвэрийн газраас ирүүлсэн авлигын эсрэг жилийн төлөвлөгөөг баталгаажуулан авч хувийн хэрэгт хадгалсан.	05	80%
11.	Арга хэмжээ 4.3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний	Үндсэн үйл ажиллагааны	0%	100%		01-06	100%

	төлөвлөгөөнд туссан тус яамнаас хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн тайлагнана.	гүйцэтгэлд эзлэх хувь					
11.1.	Арга хэмжээ 4.3.1.Хөтөлбөрт туссан тус яамнаас хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээг ялгаж, хариуцсан нэгжийн удирдлагад танилцуулах	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	-	30%	Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, 2024 оны 46 дугаар тогтоолоор баталсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус яамнаас үндсэн болон хамтран хариуцагчаар ажиллахаар туссан 22 арга хэмжээг жил жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх зохион байгуулалтыг хийж ажиллах чиглэлийг нийт албан хаагчдад цахим шуудангаар хүргүүлж танилцуулсан. Мөн хөтөлбөрийн хүрээнд тус яамнаас үндсэн болон хамтран хариуцагчаар ажиллахаар заасан 21 арга хэмжээний хэрэгжилтийг 2025 оны хагас жилийн байдлаар тайлагнасан. Нийт арга хэмжээний хэрэгжилт 57.22%, үүнээс үндсэн хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт 50%, бусадтай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт 63% байна.	01-06	20%
11.2.	Арга хэмжээ 4.3.2.Арга хэмжээний хэрэгжилтийг 01 сард багтаан тайлагнаж, тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	-	70%	"Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2024-2030/"-д тус яамнаас дангаар болон бусад байгууллагатай хамтран хариуцан хэрэгжүүлэхээр туссан арга хэмжээний 2024 оны хэрэгжилтийг Авлигын эсрэг сүлжээ цахим системд тайлагнаж, хэрэгжилтийн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Авлигатай тэмцэх газарт 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 03/235 дугаартай албан бичгээр хүргүүлэв.	01-02	70%
12.	Арга хэмжээ 4.4. Албан хаагч шилжин болон сэлгэн томилогдох, шинээр томилогдоход мэдүүлгийг	Үндсэн үйл ажиллагааны	-	100%		01-06	100%

	хянуулах хүсэлтийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ.	гүйцэтгэлд эзлэх хувь					
12.1.	Арга хэмжээ 4.4.1.Мэдүүлгийн бүрдүүлэлтийн системд албан хаагч, иргэний хувийн ашиг сонирхлын байдлаа мэдүүлэх эрхийг үүсгэх, зөвлөгөө өгөх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	-	40%	Авлигатай тэмцэх газраар нэгж хооронд шилжин томилох, шинээр томилох, хавсран ажиллуулах, эзгүй албан хаагчийн оронд түр орлон гүйцэтгэгчээр томилох нийт 44 иргэн, албан хаагчийн хувийн ашиг сонирхлын байдлыг хянуулахаар эрхийг мэдүүлгийн бүрдүүлэлтийн системд үүсгэж, заавар зөвлөмжийг цахим шуудангаар нь хүргүүлж ажилласан.	01-06	40%
12.2.	Арга хэмжээ 4.4.2.Албан хаагч, иргэний хувийн ашиг сонирхлын байдлыг хянуулах хүсэлтийг боловсруулан баталгаажуулж, Авлигатай тэмцэх газарт бүрдэл ханган хүргүүлэх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	-	30%	Тайлант хугацаанд нийт 44 албан хаагч, иргэний хувийн ашиг сонирхлын байдлыг хянуулах хүсэлтийг 11 удаагийн албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.	01-06	30%
12.3.	Арга хэмжээ 4.4.3.ХАСУМ-ийн бүртгэлийг мэдүүлгийн бүрдүүлэлтийн системийн ЭБАТ цэсэд хөтлөх	Үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд эзлэх хувь	-	30%	Иргэнийг шинээр томилох, албан хаагчийг шилжүүлэн томилоход гаргасан хувийн ашиг сонирхлыг хянасан дүгнэлт болон томилсон талаарх шийдвэрийг улирал бүр мэдүүлгийн бүрдүүлэлтийн системийн ЭБАТ цэсэд бүртгэж байна.	01-06	30%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Ажлын хэсэг, комиссын бүрэлдэхүүнд ажиллах	Хууль, эрхзүйн зөвлөгөө дэмжлэгээр бүрэлдэхүүнийг хангасан байх	-	-	Тус хэлтсийн шинжээч Б.Солонго Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны бүрэлдэхүүнд ажиллаж байна. Хорооны 2025 оны ээлжит хурал 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулагдаж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны дотоод аудитын 2025 оны жилийн төлөвлөгөөг хэлэлцэн батлав.	01	100%

					Тус яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хорооны гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Ёс зүйн дэд хороонд ирүүлсэн гомдолтой холбогдуулан 2025 оны 04 дүгээр сарын 03, 22-ны өдрүүдэд гомдол гаргагч болон гомдолд холбогдсон этгээдээс тайлбар авч, дүгнэлт гаргахаар ажиллаж байна.	01-06	100%
					Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/45 дугаар тушаалаар байгуулсан "Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах" Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/45 дугаар тушаалаар байгуулсан "Хөдөлгөөнт холбооны 2G, 3G технологид суурилсан сүлжээ, үйлчилгээг зогсоох баримтлах чиглэлийн төсөл боловсруулах", Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/84 дугаар тушаалаар байгуулсан "Сансрын тухай хуулийн төслийг боловсруулах" Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус тус ажиллаж байна.	01-06	100%
2.	Аудитад хамгаалах тайлан	Аудитын асуудлын бүртгэлд тусгагдсан асуудлуудыг хасуулах талаар аудитын багт хууль эрх зүйн талаас тайлбар өгсөн байх	-	-	Үндэсний аудитын газраас тус яаманд хийсэн санхүүгийн болон Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын шалгалттай холбогдуулан аудитын асуудлын бүртгэлд тусгасан зарим асуудлаар аудитын багт тайлбар өгөх уулзалтад Төрийн нарийн бичгийн дарга болон санхүүгийн, харилцаа холбооны хэрэгжилтийн нэгжийн албан хаагчдын хамт байлцаж, хууль эрх зүйн талаас тайлбар өгч ажилласан.	01-04	100%
3.	Хурал, уулзалтад удирдлагын чиглэлийн дагуу оролцох	Шаардлагатай тохиолдолд хууль эрх зүйн чиглэлээр асуултад хариулж, удирдаж байгаа албан тушаалтанд дэмжлэг үзүүлсэн байх	-	-	Инновац, цахим бодлогын Байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хуралд Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Бат-Өлзий, Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Ч.Болор-Эрдэнэ нарын хамт оролцсон. Тус хурлаар Инновацийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайланг хэлэлцүүлсэн.	04	100%
					Тус яам болон Үндэсний Дата төв УТҮГ-ийн хамтран 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан "Дата төвийн	04	100%

					боломж-Сорилт” сэдэвт хэлэлцүүлэгт шинжээч Б.Солонго, мэргэжилтэн О.Мөнхзаяа нар оролцсон.		
					Хууль зүйн Байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хуралд оролцсон. Тус хурлаар Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаар танилцуулж, санал авсан.	04	100%
					Инновац, цахим бодлогын Байнгын хорооны 2025 оны 06 дүгээр сарын 04-ний өдрийн хуралд Инновацын бодлого зохицуулалтын газрын дарга П.Мөнхбат, мөн газрын ахлах шинжээч М.Солонго нарын хамт оролцсон. Тус хурлаар Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтэд гарч байгаа хүндрэл бэрхшээлтэй асуудлыг судлах Байнгын хорооны ажлын хэсгийг байгуулах талаарх асуудлыг хэлэлцсэн.	06	100%
4.	Байгууллагын олон нийтийн арга хэмжээнд оролцох	Оролцоог хангасан байх	-	-	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн “Бүх нийтийн мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр Түргэний гол дагуух “Ногоон хэрэм” зурваст мод тарих үйл ажиллагаанд оролцсон.	05	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Удирдлагын академиас зохион байгуулах сургалтад хамрагдана.	Суралцсан кредит цаг	16	-	Захиалгат сургалтын квотод хамрагдаагүй болно.	07-12	-
2.	Арга хэмжээ 2. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах Эрх бүхий	Хамрагдах сургалтын тоо	3	2	Авлигатай тэмцэх газраас 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулсан “ЭБАТ-ыг чадавхжуулах цахим сургалт”-д харьяа 4 газрын ЭБАТ-ын хамт хамрагдсан.	01-12	100%

	албан тушаалтныг чадавхжуулах сургалтад хамрагдана.				Мөн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлагналтыг www.khutulbur.iaac.mn системээр авах болсонтой холбогдуулан 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Авлигатай тэмцэх газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хамтран зохион байгуулсан арга зүйн зөвлөгөө өгөх сургалтад цахимгаар хамрагдсан.		
3.	Арга хэмжээ 3. Албан хаагчдын ур чадвар, чадавхыг хөгжүүлэх байгууллагын дотоод сургалтад хамрагдана.	Хамрагдах сургалтын тоо	2	1	Инновацын бодлого зохицуулалтын газраас 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулсан "Мэдээллийн технологи, хиймэл оюун ухааны хөгжлийн чиг хандлага", Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан "Нийтийн эрх зүйн нэгдмэл байдал, чиг хандлага, шийдэл" сэдэвт хэлэлцүүлэг, Харилцаа холбооны бодлого зохицуулалтын газар, Онцгой байдлын ерөнхий газраас хамтран 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан "Гамшгийн аюулын дохиогоор ажиллах" сургалтад тус тус хамрагдсан.	01-12	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

ШИНЖЭЭЧ
(Албан тушаал)

Б.СОЛОНГО / /
(Нэр, гарын үсэг)

2025.06.06
(Огноо)